

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2026/031/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2026 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитор: М.Ухаанбилэг Утас: 7058-4204, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-10
3. Аудитын илрүүлэлт .....	10
3.1 Албан шаардлага.....	11
3.2 Зөвлөмж.....	11
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	12

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
ЗГ	Засгийн газар
СС	Сангийн сайд
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

### 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026.02.25 № 132

танай 2026.0127 ны № 34 -Т

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,  
ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.САЙХАНГЭРЭЛ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### Бусад асуудал

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас 94.8 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

• - •2125020205

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>294,611,893.90</b>	<b>325,549,607.53</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	469,938.37	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	469,938.37	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	294,141,955.53	325,549,607.53
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	294,141,955.53	325,549,607.53
35410	Бичиг хэргийн материал	720,000.00	-
35420	Аж ахуйн материал	108,789,982.53	139,280,982.53
35430	Сэлбэг хэрэгсэл	5,500,000.00	7,364,000.00
35460	Хүнсний материал	227,348.00	-
35470	Бусад хангамжийн материал	178,904,625.00	178,904,625.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>705,266,553.56</b>	<b>699,316,544.94</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	705,266,553.56	699,316,544.94
39100	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	617,550,303.56	618,725,294.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	472,587,545.80	472,587,545.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(49,415,480.04)	(60,908,560.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	43,500,000.00	43,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,416,666.40)	(43,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	181,520,302.00	238,451,902.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(47,502,969.00)	(76,783,589.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	77,082,717.26	77,082,717.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,742,645.86)	(44,704,719.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,500,000.00	20,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,562,500.20)	(7,500,000.24)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	87,716,250.00	80,591,250.00
39301	Програм хангамж	11,100,000.00	11,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,800,000.00)	(10,100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	93,810,000.00	93,810,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(7,393,750.00)	(14,218,750.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>999,878,447.46</b>	<b>1,024,866,152.47</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>(0.00)</b>	<b>1,449,092.38</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	(0.00)	1,449,092.38
<b>413</b>	<b>Өглөг</b>	(0.00)	1,449,092.38
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	156,652.38
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	(0.00)	1,292,440.00
41361	Байгууллагад төлөх өглөг	(0.00)	1,292,440.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>999,878,447.46</b>	<b>1,023,417,060.09</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	999,878,447.46	1,023,417,060.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	259,801,915.41	259,801,915.41
51101	Өмч: - төрийн	259,801,915.41	259,801,915.41
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	740,076,532.05	763,615,144.68
51210	Өмнөх үеийн үр дүн	661,891,057.89	740,076,532.05
51220	Тайланг үеийн үр дүн	78,185,474.16	23,538,612.63
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>999,878,447.46</b>	<b>1,024,866,152.47</b>

**Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,269,089,993.00</b>	<b>3,011,144,715.85</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>122,010,362.00</b>	<b>56,931,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>122,010,362.00</b>	<b>56,931,600.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	110,197,362.00	56,931,600.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	11,813,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,147,079,631.00</b>	<b>2,954,213,115.85</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,045,912,100.00</b>	<b>1,746,083,819.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,045,912,100.00	1,746,083,819.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,101,167,531.00</b>	<b>1,208,129,296.85</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	772,691,104.70	1,120,812,263.85
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	328,476,426.30	87,317,033.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,163,154,518.84</b>	<b>2,987,606,103.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,163,154,518.84</b>	<b>2,987,606,103.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,062,830,722.16</b>	<b>2,808,455,816.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>506,154,360.88</b>	<b>1,051,453,842.77</b>
210101	Үндсэн цалин	260,899,943.39	606,177,730.75
210102	Нэмэгдэл	168,165,027.89	270,620,957.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,692,500.00	124,361,248.56
210104	Урамшуулал	21,396,889.60	50,293,906.08
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>63,281,521.44</b>	<b>134,559,318.73</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,442,451.86	96,323,154.89
210202	Тэтгэмжийн даатгал	5,211,376.67	8,813,310.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,495,691.73	5,042,394.80
210204	Ажилгүйдлийн даатгал	3,008,575.34	5,770,870.30
210205	Эрүүл мэндийн даатгал	10,123,425.84	18,609,587.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,647,267.63</b>	<b>40,920,124.84</b>
210301	Гэрэл, пахилгаан	4,398,217.63	22,910,049.84
210302	Түлш, халаалт	2,070,530.00	14,866,755.00
210303	Цэвэр, бохир ус	1,178,520.00	3,143,320.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,639,140.00</b>	<b>70,767,648.00</b>
210401	Бичиг хэрэг	826,320.00	11,292,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,325,100.00	32,650,876.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	353,500.00	2,434,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	540,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,091,040.00	23,848,422.00
210408	Бараа материал акталсны зардал	9,043,180.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>760,797.00</b>	<b>70,710,039.20</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	7,728,700.00
210502	Хоол, хүнс	760,797.00	62,981,339.20
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>352,700.00</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	352,700.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>7,380,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	7,380,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>989,801,817.45</b>	<b>1,328,533,034.54</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	988,308,716.45	1,324,833,620.54
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,280.00	49,380.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,920,000.00
210807	Газрын төлбөр	1,340,146.00	710,234.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>477,045,817.76</b>	<b>103,779,108.62</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	424,869,393.96	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	40,897,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,176,423.80	62,881,608.62
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>100,323,796.68</b>	<b>179,150,286.52</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>57,032,754.00</b>	<b>19,433,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,761,254.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,271,500.00	19,433,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>43,291,042.68</b>	<b>159,717,286.52</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,291,042.68	159,717,286.52
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>105,935,474.16</b>	<b>23,538,612.63</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>27,750,000.00</b>	<b>-</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	27,750,000.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(27,750,000.00)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>78,185,474.16</b>	<b>23,538,612.63</b>

**Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,147,079,631.00</b>	<b>2,954,213,115.85</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,147,079,631.00</b>	<b>2,954,213,115.85</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,045,912,100.00	1,746,083,819.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,045,912,100.00	1,746,083,819.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,101,167,531.00	1,208,129,296.85
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	772,691,104.70	1,120,812,263.85
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	328,476,426.30	87,317,033.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,147,079,631.00</b>	<b>2,954,213,115.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,147,079,631.00</b>	<b>2,954,213,115.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,046,755,834.32</b>	<b>2,775,062,829.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	508,160,466.89	1,051,453,842.77
210101	Үндсэн цалин	275,964,974.61	606,177,730.75
210102	Нэмэгдэл	157,298,842.28	270,620,957.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,017,500.00	124,361,248.56
210104	Урамшуулал	20,879,150.00	50,293,906.08
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,745,353.80	133,932,727.98
210201	Тэтгэврийн даатгал	42,548,598.01	96,323,154.89
210202	Тэтгэмжийн даатгал	4,726,678.89	8,813,310.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,343,539.61	5,042,394.80
210204	Ажилгүйдлийн даатгал	2,343,539.61	5,144,279.55
210205	Эрүүл мэндийн даатгал	9,782,997.68	18,609,587.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,647,267.63	40,920,124.84
210301	Гэрэл, цахилгаан	4,398,217.63	22,910,049.84
210302	Түлш, халаалт	2,070,530.00	14,866,755.00
210303	Цэвэр, бохир ус	1,178,520.00	3,143,320.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,353,320.00	58,238,781.00
210401	Бичиг хэрэг	1,779,820.00	10,772,900.00
210402	Тээвэр, шатахуун	220,000.00	30,318,631.00
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	353,500.00	11,994,950.00
210404	Ном, хэвлэл	-	2,976,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	841,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,335,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	67,827,419.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	7,728,700.00
210502	Хоол, хүнс	-	60,098,719.20
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	26,998,440.00	4,881,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,998,440.00	-
210604	Урсгал засвар	7,000,000.00	4,881,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	7,380,000.00
210702	Дотоод албан томилолт	-	7,380,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,009,682,757.02	1,366,782,633.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,008,189,656.02	1,363,083,219.54
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,280.00	49,380.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,920,000.00
210807	Газрын төлбөр	1,340,146.00	710,234.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	429,168,228.98	43,646,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	429,168,228.98	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	43,646,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>100,323,796.68</b>	<b>179,150,286.52</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	57,032,754.00	19,433,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,761,254.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,271,500.00	19,433,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	43,291,042.68	159,717,286.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,291,042.68	159,717,286.52
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	259,801,915.41	0.00	674,702,033.48	0.00	934,503,948.89
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-12,810,975.59	0.00	-12,810,975.59
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>259,801,915.41</b>	<b>0.00</b>	<b>661,891,057.89</b>	<b>0.00</b>	<b>921,692,973.30</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	78,185,474.16	0.00	78,185,474.16
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>259,801,915.41</b>	<b>0.00</b>	<b>740,076,532.05</b>	<b>0.00</b>	<b>999,878,447.46</b>
D01	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>259,801,915.41</b>	<b>0.00</b>	<b>740,076,532.05</b>	<b>0.00</b>	<b>999,878,447.46</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>259,801,915.41</b>	<b>0.00</b>	<b>740,076,532.05</b>	<b>0.00</b>	<b>999,878,447.46</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	23,538,612.63	0.00	23,538,612.63
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>259,801,915.41</b>	<b>0.00</b>	<b>763,615,144.68</b>	<b>0.00</b>	<b>1,023,417,060.09</b>

**Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/төгрөгөөр/**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,937,222,400.00	1,762,358,519.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,937,222,400.00	1,762,358,519.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,871,423,500.00	1,598,024,741.96
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,059,859,500.00	971,367,995.70
210101	Үндсэн цалин	568,787,700.00	545,874,982.68
210102	Нэмэгдэл	261,922,900.00	250,837,858.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	131,154,300.00	124,361,248.56
210104	Урамшуулал	97,994,600.00	50,293,906.08
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	132,618,000.00	124,261,226.98
210201	Тэтгэврийн даатгал	90,272,900.00	87,041,653.89
210202	Тэтгэмжийн даатгал	10,586,100.00	8,813,310.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,293,300.00	4,652,394.80
210204	Ажилгүйдлийн даатгал	5,293,300.00	5,144,279.55
210205	Эрүүл мэндийн даатгал	21,172,400.00	18,609,587.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	53,952,100.00	30,088,082.09
210301	Гэрэл, цахилгаан	21,531,000.00	12,078,007.09
210302	Түлш, халаалт	27,309,300.00	14,866,755.00
210303	Цэвэр, бохир ус	5,111,800.00	3,143,320.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	83,527,900.00	58,238,781.00
210401	Бичиг хэрэг	16,406,100.00	10,772,900.00
210402	Тээвэр, шатахуун	36,538,900.00	30,318,631.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,809,700.00	11,994,950.00
210404	Ном, хэвлэл	3,807,300.00	2,976,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,302,800.00	841,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,663,100.00	1,335,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	95,718,900.00	67,827,419.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,231,500.00	7,728,700.00
210502	Хоол, хүнс	72,885,600.00	60,098,719.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,601,800.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,881,300.00	4,881,300.00
210604	Урсгал засвар	4,881,300.00	4,881,300.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	24,306,400.00	7,380,000.00
210702	Дотоод албан томилолт	24,306,400.00	7,380,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	395,283,600.00	312,731,936.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	386,412,600.00	309,032,522.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,489,700.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	449,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	94,500.00	49,380.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,047,700.00	2,920,000.00
210807	Газрын төлбөр	770,300.00	710,234.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,275,800.00	21,248,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,275,800.00	21,248,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	65,798,900.00	164,333,777.04
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	65,798,900.00	19,433,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,600,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	61,198,600.00	19,433,000.00
<b>26</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>	-	144,900,777.04
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	144,900,777.04
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,937,222,400.00</b>	<b>1,762,358,519.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,937,222,400.00</b>	<b>1,762,358,519.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,937,222,400.00	1,762,358,519.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>46.00</b>	<b>52.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	36.00	38.00
620004	Гэрээт ажилтан		4.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>46.00</b>	<b>52.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	36.00	38.00
650010	Гэрээт ажилтан		4.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,191,854,596.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,191,854,596.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,177,038,087.37
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	80,085,847.07
210101	Үндсэн цалин	60,302,748.07
210102	Нэмэгдэл	19,783,099.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	9,671,501.00
210201	Тэтгэврийн даатгал	9,281,501.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	390,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	10,832,042.75
210301	Гэрэл, цахилгаан	10,832,042.75
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,054,050,696.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,054,050,696.55
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,398,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,398,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	14,816,509.48
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	14,816,509.48
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	14,816,509.48
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,191,854,596.85</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,191,854,596.85
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,104,537,563.85
131104	Дэд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	87,317,033.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 370,879.2 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 282,069.7 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага, 64,804.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч, санхүүгийн тайлан хуулийн хугацаа хоцроож ирүүлсэнд сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 370,879.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 326,065.1 мянган төгрөгөөр илүү боловч шинж чанарын хувьд шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй 258,421.7 мянган төгрөг, өмнөх аудитын шийдвэр хэрэгжээгүй 24,000.0 мянган төгрөгийн зөрчлүүд нь хуулийн хэрэгжилттэй холбоотой нийцлийн зөрчил тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

**3.1 Албан шаардлага**

3.1.1. Дорнод аймагт хэрэгжиж буй хүүхэд хамгааллын "Хүүхэд эрдэнэ", хүүхэд хөгжлийн "Хүн болох багаасаа" төслийн хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/196, 2025 оны А/266 дугаар захирамжуудаар байгуулагдсан ажлын хэсэгт аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хүүхдийн улсын байцаагч, хүний нөөцийн мэргэжилтэн, Цагдаагийн газрын хүүхдийн мэргэжилтэн нар уг төслийн ажлын хэсгийн нарийн бичиг, дэд дарга, гишүүнээр томилогдон ажиллахдаа нийт 23.6 сая төгрөгийн урамшуулал авч ажилласан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай 10 дугаар зүйлийн 10.2-т "Үндэсний

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, Мөн Шилэн дансны цахим сайтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 159.4 сая төгрөгийн 13 гүйлгээ, зарлагын 99.0 сая төгрөгийн нийт 10 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.1.2. Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2026.01.27-ны өдрийн 34 дугаартай албан бичгээр Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;" Мөн Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас 2023 оны 10 сард Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар тогтоосон 01/73 ДОА-2024/09/НА-СТА-ТШЗ А1170309 дугаартай 24.0 сая төгрөгийн төлбөрийн актыг одоог хүртэл барагдуулаагүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэсэн заалтын дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

### 3.2 Зөвлөмж

3.2.1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн данс бүртгэлд 2016-2019 онд ашиглалтад орсон элэгдлийн хэмжээ ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн нийт 64,8 сая төгрөгийн 13 ширхэг хөрөнгийг дахин үнэлгээ хийх, ашиглалтгүй хөрөнгийг бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулаагүй, эрх бүхий байгууллагад хандаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Элэгдлийн хэмжээ ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлгээ хийх, ашиглалтгүй хөрөнгийг бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах зөвлөмж өгөв.

3.2.2. Бүтэц орон тоотой холбоотой

**Илрүүлэлт:** Дорнод аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын батлагдсан бүтэц орон тооноос илүү 4 гэрээт ажилтныг аймгийн ЗДТГ-аас цалинжуулан ажиллуулж байна.

**Өгсөн зөвлөмж:** Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл"-д "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ". Харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ажлын хэсгийн гишүүд урамшуулал авсан	1	23,648.0	-	-	1	23,648.0	-	-	-	-	-	-
Элэгдлээ нөхсөн хөрөнгөнд арга хэмжээ авч ажиллах	1	64,809.5	-	-	-	-	1	64,809.5	-	-	-	-
Өмнөх аудитаар тогтоосон барагдаагүй төлбөрийн акт	1	24,000.0	-	-	-	-	-	-	1	24,000.0	-	-
Төсвийн тухай хуульд заасан цаглабар зөрчсөн	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Шилэн данстай холбоотой	1	258,421.7	-	-	1	258,421.7	-	-	-	-	-	-
Бүтэц орон тоог 9 хувиар бууруулахтай холбоотой	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>370,879.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>282,069.7</b>	<b>2</b>	<b>64,809.5</b>	<b>2</b>	<b>24,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>